

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Нийтийн албан тушаалтны хууль бус
хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх,
нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл
болон түүнийг дагалдуулан боловсруулсан
бусад хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулийг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж хуульчлан төрийн үйл ажиллагааны нийтээр дагаж мөрдөх суурь зарчим болон авлигаас ангид байх төрийн бодлогын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнчлэн Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэж хуульчлан иргэн өмчийн эрхээ шударгаар хэрэгжүүлэх суурь зарчмыг мөн тунхаглан баталгаажуулсан байна.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл болон дагалдуулан багцлан боловсруулсан хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтуудыг хангахад чухал алхам болох юм.

Түүнчлэн, Монгол Улс а)авилгалын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсэж буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгаад сэтгэл зовниж; б)эд баялгийг хувьдаа хууль бусаар олж авах нь ардчилсан тогтолцоо, үндэсний эдийн засаг, хууль дээдлэх ёсонд нэн хохиролтой гэдэгт итгэж; с)эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхэд эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний буюу захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудыг баримтлахыг хүлээн зөвшөөрч, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан “Авлигалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-д 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгаснаар “... хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” хэмээх зорилгыг тодорхойлж, улмаар тус зорилгыг хэрэгжүүлэхээр “Авлигагүй засаглал” буюу “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээх зорилтуудыг дэвшүүлсэн.

Түүнчлэн тус зорилтуудыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.” гэж, “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэрэг буурсан байна.” хэмээх үр дүнд хүрэхээр тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрөөр улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөрчилж, олон нийтийн итгэлийг хүлээн авлигаас ангиж

нийтийн албыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх, хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулах, **авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох**, төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулах зэрэг зорилгуудыг дэвшүүлсэн байна.

Тус “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилго 6-д “Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, Зорилт 6.1-д “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана.” гэж, 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.1.5-д “Авлигын гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлж тодорхойлно.” гэж, 6.1.10-т “Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлнэ.” гэж, 6.2.5-д “Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.” гэж, 6.3.1-д “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.3.2-т “Оффшор бүс, гадаад улсаас шилжүүлэн авсан хууль бус хөрөнгө, орлого, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх явцад хураасан хөрөнгийг нээлттэй, ил тод байдлаар зарцуулах тогтолцоог бий болгоно.” гэж, 6.3.3-т “Нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө буцаах болон захиран зарцуулах нөхцөл, журам, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 6.4.2-т “Авлигын гэмт хэрэгт үгсэн тохиролцож, хууль бусаар давуу байдал олж авсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгоно.” гэж, 7.5.2-т “Төрийн аудитын тухайн жилийн сэдвийн төлөвлөлт, аудитын үр дүнг олон нийтэд ил тод мэдээлж, эргэх холбоо тогтоох нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 7.5.3-т “Засгийн газрын хяналт шалгалт, төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж авлигагүй нийгмийг бий болгоход чиглэсэн, ач холбогдол бүхий томоохон бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан гол зорилт болох Зорилт 16-д “санхүүгийн ... хууль бус урсгалыг мэдэгдэхүйц бууруулах, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагааг бэхжүүлэх, бүх төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” гэж мөн онцлон тодотгон тусгасныг нэмж дурдах нь зүйтэй.

Авлигатай холбогдох зарим нөхцөл байдал

1.Монгол Улс “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын 2023 оны Авлигын төсөөллийн индексээр манай улс 180 улсаас 2018 онд **93**, 2019 онд 106, 2020 онд 111, 2021 онд 110-т эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 6 байраар

ухарч 116-д, 2023 онд өмнөхөө оны эрэмбээс 5 байраар ухарч 121-д эрэмбэлэгдсэн муу үзүүлэлттэй байна.

2.Авлигатай тэмцэх газраас 2017-2023 онуудад нийт **8860** авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас **1578** хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар, **2988** хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай шийдвэрлэж байсан байна.

2017-2023 онуудад Прокурорын байгууллагаас нийт **7229** авлигын гэмт хэрэгт хяналт тавьж ажилласнаас **1005** хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, **121** хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Прокурорын байгууллагаас шүүхэд 2017-2023 онуудад шилжүүлсэн 1005 хэргээс шүүх нийт **739** хэргийг нь шийдвэрлэж, 20 хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн хэрэг нь хянан шийдвэрлэх шатанд байна.

Үүнээс үзвэл, 2017-2023 онуудад мөрдөн шалгах ажиллагаа хийгдсэн **8860** авлигын гэмт хэргийн **739** буюу **8,3 хувь** нь л шүүхээр шийдвэрлэгдэж, мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд нийт **3129** хэрэг буюу **35 орчим хувь** нь хэрэгсэхгүй болж шийдвэрлэгджээ.

Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч, улсын орлого болгосон эсэхэд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд 2018-2023 онуудад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан авлигын хэргийн гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирлын хэмжээ **1.5 их наяд төгрөг**, битүүмжилсэн хөрөнгийн үнийн дүн **865.4 тэрбум төгрөг** байсан ба Прокурорын байгууллагаас эдгээр онуудад нийт **14.9 тэрбум** төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгө орлого хураан авсан байна.

Гэтэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн 2018-2023 онуудад шүүхээс авлигын хэргийг хянан шийдвэрлэсэн тоон мэдээллээс үзвэл авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хураан авсан талаар тоон мэдээлэл гараагүй.

Авлигатай тэмцэх газраас 2013-2017 онуудад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн тухайд эдгээр гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирлын хэмжээ 299,8 тэрбум төгрөг байснаас 20.3 тэрбум төгрөгийн хохирлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ. Мөн эдгээр онуудад Авлигатай тэмцэх газраас 85.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээллээс үзвэл 2013-2017 онуудад гэмт хэрэг үйлдэж олсон **400 сая** төгрөгийн хөрөнгө, орлогыг хураан авсан байна. Энэ нь эдгээр онуудад гарсан албан тушаалын гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын **0.1 хувьтай**, битүүмжилсэн хөрөнгийн **0.4 хувьтай** тэнцэж байна.

Хууль бус буюу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадан нэвчлэх хэмжээг хэрэглэж байна" гэж тусгажээ гэдгээс 7.5 дүгээр

зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг зөвхөн тодорхойлох байдлаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг заавал хураах, нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.

Харин 2002 онд батлагдан мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эд хөрөнгө хураах ял оногдуулсан эсэхээс үл хамааран заавал хураах зохицуулалттай байжээ.

3.Авлигын эсрэг хуульд заасан, нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэх процесс, үүнээс гадна хураасан хөрөнгө, орлогыг эрхлэн удирдах, эрхлэн удирдсанаас олсон орлогыг зарцуулах, тайлагнах эрх зүйн орчин тодорхой бус, түүнчлэн авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах талаар хуулийн зохицуулалтгүй байна.

Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж, мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.”-оор тус тус хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байна.

4.Сүүлийн жилүүдэд эрх бүхий байгууллагад бүртгэгдэж, шүүхээс таслан шийдвэрлэгдсэн авлигын, ялангуяа нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэргүүдээс үзэхэд, гэмт этгээд бусдаас тэрбум, түүнээс дээш хэмжээний хахууль авсан болох нь тогтоогдож, иргэдийг ихээр бухимдуулж байна. Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан их хэмжээний хахууль буюу нэг зуун сая төгрөгөөс дээш хэмжээний хахууль авсан бол тухайн этгээдэд Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа бөгөөд тодруулбал, нэг зуун сая төгрөгийн хахууль авсан, нэг зуун тэрбум төгрөгийн хахууль авсан этгээдийн үйлдэлд Эрүүгийн хуулийн адил зүйл, хэсгээр зүйлчилж, адил ял оногдуулж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй байгаа юм.

Түүнчлэн тус гэмт хэргийн шинжийг “Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол ..” гэж Эрүүгийн хуульд тодорхойлсон нь нийтийн албан тушаалтан хээл хахуулийг өөртөө авалгүйгээр “төлөөний хүн”-д хээл хахуулийг өгүүлсэн үйлдэл тус гэмт хэргийн шинжид хамаарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тус гэмт хэргийг үйлдэгч нарт ял оноох, хариуцлага ногдуулах боломжгүй хийдэлтэй зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

5.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг хэлбэрийн шинжтэйгээр /хохирлын хэмжээ шаардахгүй/ хуульчилсан нь хохирол өндөр, багаас үл хамааран адилхан ял шийтгэл хүлээхээр байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна." гэж заасан шударга ёсны зарчимтай мөн нийцэхгүй юм.

6.Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэрэг нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг хэдий ч энэ гэмт хэргийн субъектив талын шинжид гэм буруугийн хэлбэрийг тодорхой зааж өгөөгүйн улмаас практикт хайнга хандах гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (22.1) гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна.

Мөн практикт Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учирдаг. Тус гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж, авлигын гэмт хэрэг үйлдсэн нийтийн албан тушаалтан хөнгөн ял шийтгэгдэх, улмаар нийтийн албанд ажиллах, хууль тогтоох дээд байгууллагын сонгуульд нэр дэвших боломжийг бүрдүүлсэн хийдлийг засах шаардлагатай болжээ.

7.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр манай улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох эрсдэлтэй гэмт хэргийг үнэлсэн бөгөөд уг үнэлгээгээр 1.авлигын, залилах, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүд өндөр эрсдэлтэй, 2.татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд дунд эрсдэлтэй, 3.хөрөнгө завших, хулгайлах, мал хулгайлах гэмт хэргүүд бага-дунд эрсдэлтэй, 4.улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд бага эрсдэлтэй гэж дүгнэжээ.

Гэвч мөнгө угаах гэмт хэргийг сүүлийн 4 жил эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 193 хүнд холбогдох 172 хэргийг шийдвэрлэжээ. Нийт суурь гэмт хэргээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 154 буюу 90.5 хувийг, эдийн засгийн гэмт хэрэг 2 буюу 1 хувийг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг, авлигын гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 2.3 хувийг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн дийлэнх хувийг өмчлөх эрхийн эсрэг (хулгайлах, мал хулгайлах, залилах, дээрэмдэх) гэмт хэрэг эзэлж байна.

Мөнгө угаах гэмт хэргээр нийт 193 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэснээс бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаасан хүн 160 буюу 83 хувийг, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаасан хүн 33 буюу 17 хувийг тус тус эзэлж байгаа судалгаа байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт бүх гэмт хэргийг хамаарахаар хуульчилсан байтал зөвхөн дээр

дурдсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн хүрээнд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлэх практик тогтсон гэж үзэж болохоор байна.

8.Авлигатай тэмцэх газар улсын хэмжээнд авлигын гэмт хэргийг дангаараа мөрдөн шалгаж байгаа нь авлигатай үр дүнтэй тэмцэхэд хүчин мөхөсдөж байна. Ялангуяа орон нутагт гарсан авлигын гэмт хэргийг орон нутагт салбар, нэгжгүй Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгахад хүндрэлтэйгээс гадна орон нутагт гарсан авлигын хэрэг даамжрах эрсдэлтэй байна. Иймд авлигын гэмт хэрэгт, тодруулбал, цагдаагийн байгууллага өөрсдөө илрүүлсэн, эсхүл орон нутагт гарсан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааг цагдаагийн байгууллагын хүчин чадлыг ашиглан явуулахаар хуульчлах нь зүйтэй байна.

9.Төрийн аудитын байгууллагаас 2020-2024 онд гүйцэтгэсэн аудитын явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул прокурорын байгууллагад мэдэгдэж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар нийт 67 асуудлыг холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлэн хүргүүлсэн нь бүгд төсвийг хууль бусаар зарцуулсан зөрчлүүд байсан байна.

Дээрх шилжүүлсэн 67 хэргээс 9 нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэгдсэн байх ба 58 нь харьяаллын дагуу шалгагдахаар Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагад шилжсэн байна.

Төрийн аудитын тухай хуульд төрийн аудитын байгууллагын тогтоосон хүчин төгөлдөр төлбөрийн акт, албан шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ гэж заасан ч нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг байна.

Хууль тогтоомжид Төрийн аудитын тухай хуульд зааснаас өөрөөр зааж зарим байгууллага төрийн аудитад хамрагдахгүй үлдэх боломжийг олгосон байдаг. Жишээлбэл, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ.” гэж заажээ.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг хангах зорилгоор манай улс орны авлигын зарим нөхцөл байдлыг харгалзан холбогдох судалгааг хийсний үндсэн дээр Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт дараах үндэслэл, гол агуулгатайгаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.4-т “Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.” гэж, 14.5-т “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.” гэж тус тус заасны дагуу багцлан боловсруулаад байна:

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн талаар:

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг, тухайлбал, тус зүйлийн 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих”-ийг хориглож, албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж үзнэ гэж хуульчилжээ.

Мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох”-оор хуульчилсан ч тус заалтыг хэрхэн хэрэгжүүлэх буюу процессын зохицуулалтыг хуульчлаагүй байна.

Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэж заасан тул Авлигын эсрэг хуулийн дээр дурдсан заалтыг хэрэгжүүлэх процессыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэх боломжгүй юм.

Мөн Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг 100 сая хүртэл хэмжээнийх дээр агуулаагүй тул хэрэгжүүлэх процессыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар явуулах боломжгүй юм.

Иймд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэх үндэслэл, журмыг эрүүгийн, зөрчлийн процессоос тусдаа процессжуулан хуульчлах нь зүйтэй гэж үзэж энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Энэхүү хуулийн төслийг 11 бүлэг, 62 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд төсөлд дараах зохицуулалтыг тусгаад байна. Үүнд:

1/Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, зохицуулах харилцаа, албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэх тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт зэргийг тусгалаа.

Хуулийн зорилгыг:

- Төр, нийтийн зөрчигдсөн ашиг сонирхлыг сэргээх, учруулсан гэм хорыг арилгуулах үүднээс нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хурааж авах, нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэл, журмыг тогтоох замаар нийтийн алба дахь авлигыг таслан зогсоох,
- авлига дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх,
- авлигагүй нийтийн албыг бий болгох гэж тодорхойллоо.

Тус хуулиар нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагаа (цаашид “хууль бус

хөрөнгийг хураан авах ажиллагаа” гэх)-ны үндэслэл, журам болон эдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулах юм.

Хуулийн үйлчлэх хүрээний тухайд нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, түүний шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, эрхэлж байсан болон эрхэлж байгаа албан тушаалын байдал, эрх нөлөөгөөр бий болсон, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй, эсхүл хууль бус аргаар олж авсан эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлогыг хурааж авах, нөхөн төлүүлэхэд үйлчлэх ба нийтийн албан тушаалтан Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд заасан авлигын зөрчлийн улмаас олсон хөрөнгийг хууль бус хөрөнгөд хамааруулж иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах, нөхөн төлүүлэхэд үйлчлэхээр тусгалаа.

Хуулийн төсөлд тус хуульд хэрэглэсэн чухал нэр томьёонуудыг тодорхойллоо. Тухайлбал, хууль бус орлого, хууль бус орлогоос бий болсон хөрөнгө, хууль бус хөрөнгө, хөрөнгө гэх мэт нэр томьёог нэг бүрчлэн томьёолсон. Хөрөнгө гэж бүх төрлийн эдийн болон эдийн бус хөрөнгө буюу бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эрх, бодит эсвэл биет бус, шилжих боломжтой эсвэл шилжих боломжгүй, үнэлэгдэх боломжтой эсвэл үнэлэгдэх боломжгүй үнэ өртөг бүхий ашиг, эсвэл эд зүйлс, орлого, эсвэл ямар нэгэн бараа болгон хувиргасан буюу холилдсон эд зүйлс, виртуал хөрөнгийг, хууль бус хөрөнгө гэж хууль бус орлого болон хууль бус орлогоос бий болсон хөрөнгийг ойлгох бөгөөд тухайн нөхцөл байдлаас үл хамааран хууль ёсны орлогоор олж авах үндэслэлгүй хөрөнгө, түүний иж бүрдэлд хамаарах хөрөнгө, энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу дараа нь олж авсан, түүнчлэн тухайн хөрөнгийг ашигласнаас олсон, бий болсон хөрөнгө, орлогыг ойлгохоор тодорхойллоо.

Мөн “нийтийн албан тушаалтан” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.9-д заасан албан тушаалд ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүн, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн, эдгээртэй адилтгах албан тушаалд ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүн буюу улсын болон орон нутгийн төсвөөс цалин хөлс авч ажилладаг, төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг албан тушаалтнаар томилогдон, эсхүл сонгогдон, түр болон байнгын орон тоон дээр ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүнийг ойлгохоор тусгалаа.

Улмаар нийтийн албан тушаалтны хамаарал бүхий этгээдийг тодорхойлж, үүнд нийтийн албан тушаалтны гэр бүлийн гишүүн, үр хүүхэд, төрөл, садангийн хүн, нэгдмэл сонирхолтой этгээд, Эрүүгийн хуульд заасан төлөөний хүн, бэлэглэл, гэрээслэлээр хөрөнгө хүлээн авсан этгээдийг хамаарахаар тусгасан.

Тус хуулийн төсөл дэх гол нэр томьёо болох “хураан авах” гэж төр, нийтийн зөрчигдсөн ашиг сонирхлыг сэргээх, учруулсан гэм хорыг арилгуулах зорилгоор, энэ хуульд заасан үндэслэл, журмаар нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчээс гаргуулж улсын орлого болгохыг ойлгохоор тусгав.

2/Хоёрдугаар бүлэгт нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ерөнхий зарчмын зохицуулалтыг тусгасан. Нэн түрүүнд “Шударга ёсны зарчим” нь хөрөнгөөс төрөөс хураан авах, нөхөн төлүүлэх

1.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогоогүй нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй ба тус заалт нь холбогдох гэмт хэрэгт гэм буруугүйг нь шүүхээс тогтоосон, цагаадсан этгээдэд хамаарахгүй байхаар тусгасан.

2.Нийтийн албан тушаалтны хөрөнгө нь хууль ёсны эсэхэд цугларсан нотлох баримт, нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлд дүгнэлт хийж шийдвэрлэхээр тусгалаа.

3.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааг тухайн хөрөнгөтэй холбогдуулан явагдаж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай нэг цаг хугацаанд давхардуулан явуулахгүй байхаар тусгав.

4.Нийтийн албан тушаалтны холбогдсон гэмт хэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар хянан шийдвэрлэж прокурор хэрэг бүртгэлийг хаасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, эсхүл шүүхээс эрүүгийн хэргийг шийдвэрлэж шүүхийн шийтгэх тогтоол гаргахдаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураалгүйгээр, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг нөхөн төлүүлэх зорилгоор эд хөрөнгө хураах ял оногдуулалгүйгээр шийдвэрлэсэн нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг явуулахад саад болохгүй байхаар тусгав.

5.Тухайн нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэх, нас барсан, оргон зайлсан эсэхээс үл хамааран хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг явуулахаар тусгалаа.

Түүнчлэн хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үйл ажиллагааны үндэслэл, бусад зарчмуудыг тусгалаа:

- аливаа хөрөнгө хууль ёсны эх үүсвэртэй байх;

- нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоос давсан хэмжээний хөрөнгийнхөө эх үүсвэрийг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй, эсхүл тайлбарласан нь нотлогдоогүй бол уг хөрөнгийг хууль бус гэж үзэх;

- нийтийн албан тушаалтнаас хураан авсан, нөхөн төлүүлсэн хууль бус хөрөнгийг улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

- хууль бус хөрөнгө хууль ёсны хөрөнгөтэй нийлсэн, холилдсоны үр дүнд бий болсон хөрөнгөөс зөвхөн хууль бус хэсгийг хураан авах;

- хууль бус хөрөнгийг хураан авахдаа түүнийг хууль бус болохыг мэдээгүй, мэдэх боломжгүйгээр, хууль ёсны дагуу хийсэн, өв залгамжлал, бэлэглэл, гэрээслэлээс бусад хэлцлийн үндсэн дээр шилжүүлэн авсан өмчлөгч, эзэмшигчийн эрхийг хамгаалах;

- нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хууль ёсоор бусдын өмчлөлд шилжсэн бол тухайн хөрөнгийг үнэлж нийтийн албан тушаалтнаар нөхөн төлүүлэх;

- тухайн хөрөнгийг хууль ёсны эх үүсвэргүй болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, тухайн хөрөнгийг хураан авах;

-нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах үндэслэлийг тодорхойлох, хураах ажиллагааг зөвхөн шүүхэд талууд мэтгэлцэх журмаар хэрэгжүүлэх;

-хууль бус хөрөнгө бий болсон цаг хугацааг нийтийн албан тушаалтны албан тушаалын бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн хугацаатай заавал хамтатган авч үзэх;

-хууль бус хөрөнгийг өв залгамжлал, бэлэглэл, гэрээслэлээр бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд түүнийг хүлээн авсан этгээд хууль бус хөрөнгө гэдгийг мэдээгүй байх нь хууль бус хөрөнгийг хураан авахад саад болохгүй;

-аливаа этгээд тухайн хөрөнгийг хууль бусаар олж авсан, эсхүл хууль бусаар олж авсан хөрөнгөөс бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж тухайн хөрөнгийг шилжүүлж авсан бол тухайн этгээдээр нөхөн төлүүлэх.

Нийтийн албан тушаалтны хууль ёсны орлогоос нь давсан хөрөнгийг энэ хуульд заасан мөрдөгч, прокурор тогтоох бөгөөд нийтийн албан тушаалтан тухайн хөрөнгийг хууль ёсоор олсноо үндэслэл, нотолгоотой тайлбарлаж чадаагүй бол тухайн хөрөнгийг хууль бус хөрөнгө гэж үзэхээр тусгасан.

3/Гуравдугаар бүлэгт хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг хэрэгжүүлэгч, тус ажиллагааны оролцогчийн талаар тусгасан.

Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг хэрэгжүүлэгч нь шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагын мөрдөгч байх бөгөөд Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага нь өөрсдөө илрүүлсэн хууль бус хөрөнгөнд шалгах ажиллагааг тус хуульд заасан үндэслэл, журмаар явуулна.

Прокурор нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагааны үр дүнг үндэслэн хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэхээр иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах бөгөөд шүүх нэхэмжлэлийг энэ хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлан шийдвэрлэх юм.

Монгол Улс Иргэний хуулиар хууль ёсоор хөрөнгө олж авах, өмчлөх, эзэмшихтэй холбоотой суурь зохицуулалтыг хуульчилж өгсөн. Тухайлбал, Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6-д "...гэм хор учруулах, үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болно" гэж, 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.4, 9.4.5-д "эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх, учруулсан хохирлыг арилгуулах, эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар иргэний эрхийг хамгаална" гэж, 83 дугаар зүйлийн 83.1-д "**Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.**" гэж, 89 дүгээр зүйлийн 89.1-д "**Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ.**" гэж, 90 дүгээр зүйлийн 90.1-д "**Хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж байгаа буюу түүнийг эзэмших эрхтэй болох нь тодорхой байгаа этгээдийг шударга эзэмшигч гэнэ.**" гэж, 93 дугаар зүйлийн 93.1-д "**Эд хөрөнгийг хууль ёсны эзэмшигчээс шаардаж болохгүй.**" гэж, 187 дугаар зүйлийн 187.1-д "**Үүрэг нь энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр үүснэ.**" гэж, 492 дугаар зүйлд бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэнээс үүсэх үүрэг, 497 дугаар зүйлийн 497.1-д "**Бусдын эрх,**

хөрөнгөд **хууль бусаар** санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” гэж тус тус хуульчилсан байна.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заажээ.

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зохицуулалтууд нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх асуудлыг иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлэх болсон хууль зүйн гол үндэслэл болж байна.

Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт “хөрөнгө шалгах ажиллагааны оролцогч” гэж холбогдогч нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд, гэрч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, гуравдагч этгээд буюу иргэний нэхэмжлэгчийг ойлгохоор тусгасан бөгөөд хөрөнгө шалгах ажиллагааны эдгээр оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийн талаар энэхүү гуравдугаар бүлэгт оролцогч тус бүрээр тусгалаа.

4/Дөрөвдүгээр бүлэгт хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргахтай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Хүсэлт, гомдлыг ямар зорилгоор гаргахыг ялган тусгасан бөгөөд хүсэлт, гомдлыг хөрөнгө хураан авах ажиллагааны аль ч үед гаргаж болохоор тусгаж, хүсэлт, гомдол гаргах журам, хүсэлтийг шийдвэрлэх, гомдлыг шалган шийдвэрлэх журам, хүсэлт, гомдлыг хэргийн материалд хавсаргах зохицуулалтуудыг тусгасан.

5/Тавдугаар бүлэгт хөрөнгө хураан авах ажиллагааны нотлох баримтын талаар буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авлигын эсрэг хууль, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулсан баримт мэдээллийг нотлох баримтаар тооцох, мөрдөгч, прокурор нотлох баримт цуглуулах, нотлох баримтыг үнэлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

6/Зургадугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах үндэслэлийг тодорхойллоо.

1.Нийтийн албан тушаалтан холбогдсон, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хянан хэлэлцсэн шүүхийн шийтгэх тогтоолоор тухайн нийтийн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдийн хууль бус хөрөнгийг нь хураагаагүй, эсхүл бүрэн илрүүлж хураагаагүй, эсхүл хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ хэрэглээгүй бөгөөд хууль бус хөрөнгө байна гэж үзэх хангалттай үндэслэл байвал;

2.Энэ хуульд заасан хууль бус хөрөнгө байгаа гэж үзэх хангалттай үндэслэл байгаа боловч дараах үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд:

9/Есдүгээр бүлэгт хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тусгасан бөгөөд прокурор нэхэмжлэлийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу гаргах, нэхэмжлэлд үндэслэл, шаардлагыг тодорхойлж, холбогдох материалыг хавсарган хүргүүлэх үүрэг бус хөрөнгө хураан авах шаардлага гаргахад хууль

хэлэлцэх хугацаа хамаарахгүй байхаар, түүнчлэн тус нэхэмжлэл улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөхөөр, шүүх нь хөрөнгө шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг үндэслэн энэ хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг шийдвэрлэхээр, шүүх хууль бус хөрөнгийг хураан авсан, нөхөн төлүүлсэн тухай шийдвэртээ тухай хөрөнгийг улсын орлого болгож төрийн өмчлөлд шилжүүлэх талаар тусгах, хууль бус хөрөнгийг шилжүүлэн авсан этгээдээс хураан авахтай холбоотой зохицуулалт орууллаа.

10/Аравдугаар бүлэгт олон улсын хамтын ажиллагааны талаар тусгахдаа хууль бус хөрөнгийг буцаах асуудлаар гадаад улстай хамтран ажиллаж харилцах байгууллагыг Ерөнхий прокурорын газар болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхаар тусгалаа.

11/Арван нэгдүгээр бүлэгт хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааны цахим мэдээллийн санг Прокурорын байгууллага хариуцан эрхлэн хөтлөхөөр тусгаж, тус мэдээллийн санд оруулах мэдээллийн төрөл, прокурор нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан мэдээллийн нууцыг хангах үүргээ биелүүлж, хууль бус хөрөнгө хураах ажиллагаа, түүний үр дүнгийн талаарх тайланг жил бүр нийтэлж байхаар зохицуулалт орууллаа.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгав.

Дагаж гарах хуулийн төслүүд:

1.Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Тус хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах асуудалд хөөн хэлэлцэх хугацаанаас хамааран хураан авах боломжгүй байдал үүсгэхгүй байх зорилгоор нийтийн эрх ашигт гэмт хор учруулснаас үүсэх үүрэг, гэм хор арилгахтай холбоотой шаардлага гаргахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байх нэмэлт оруулахаар тусгалаа.

Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үндэслэлийг хуульд тодорхой тусгах зорилгоор хууль бусаар, үндэслэлгүйгээр, эсхүл бусдыг хохироож хөрөнгө, ашиг олсон бол тухайн хөрөнгө, ашгийг буцаан төлөх, гэм хорыг хариуцан арилгах, түүнчлэн авлигын улмаас хөрөнгө олж авсан, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн эрх ашигт гэм хор учруулсан гэж үзэх бөгөөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээхээр тус хуулийн төсөлд тусгалаа.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Тус хуулийн төсөлд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан журмыг нэмж тусгасан.

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны

дагуу явуулсан хөрөнгө шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэрлэхээр, хөрөнгө шалгах ажиллагаанд шалгагдаагүй нотлох баримтыг шүүхэд гаргасан тохиолдолд шүүх түүнийг үнэлэхгүй бөгөөд харин шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тохиолдолд энэ нь хамаарахгүй байхаар тусгалаа.

Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх явцад хариуцагч шинээр нэмэлт нотлох баримт гаргаж өгч болох ба энэ тохиолдолд уг баримтыг шүүх хэрэгт ач холбогдолтой гэж үзвэл хөрөнгө шалгах ажиллагаанд тус нотлох баримтыг шалгуулахаар шилжүүлэхээр, энэ тохиолдолд тухайн баримт шалгагдаж дуусах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэхээр тусгасан.

Хэргийг шүүхээр шийдвэрлэх хугацааны тухайд шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 30 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэхээр, тус хугацааг шаардлагатай гэж үзвэл нэг удаа 7 хүртэл хоногоор сунгаж болохоор зохицуулалт орууллаа.

Шүүхээс хэргийг шийдвэрлэх хугацааг 30 хоног гэж тусгасантай холбогдуулан мэдэгдэх хуудас, нэхэмжлэл хүргүүлэх, хүргүүлсэнд тооцох тусгайлсан зохицуулалтыг тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай адил байдлаар зохицуулалт оруулан тусгалаа.

Бас нэг гол зохицуулалтын тухайд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслөөр нэхэмжлэлд гаргах чиг үүргийг прокурорт хүлээлгэж байгаатай холбогдуулан Иргэний хэрэг үзэхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулж "Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар, **эсхүл хуульд заасны дагуу** иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно." гэж тусгав.

Төрийн аудитын байгууллагын тогтоосон хүчин төгөлдөр төлбөрийн акт, албан шаардлагын гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулахаар тус хуулийн 184 дүгээр зүйлд нэмэлт оруулахаар тусгалаа.

3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид:

Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас гадна яллагдагч, шүүгдэгч нас барсан, өршөөлд хамрагдсан, яллагдагч, шүүгдэгч оргон зайлсан эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгохоор хүрээг өргөжүүлсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 29 дүгээр зүйл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын 11 дүгээр зүйл, авлигын зарим гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэхэд урт хугацаа шаардагддаг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 22.1, 22.4, 22.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 20 жил байх өөрчлөлтийг тусгав.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 37 дугаар зүйл болон авлигын гэмт хэргийн онцлог, илрүүлэх, шалган шийдвэрлэхэд хүндрэлтэй байдлыг харгалзан авлигын гэмт хэргийг илрүүлэхэд бодитой тусалсан хамтран ажилласан этгээдийг шүүхээс энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болох өөрчлөлтийг тусгав.

Шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэж болох, эсхүл хэрэглэхгүй байж болохоор заасан байсныг гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, орлого олсон бол заавал хураан авах; эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүнээс албадан гаргуулах өөрчлөлтийг тусгав.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж шүүхийн шийдвэрээр хураан авсан хөрөнгө, орлогыг энэ хуультай хамт өргөн мэдүүлсэн Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу зарцуулж, гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх өөрчлөлтийг тусгав.

Эрүүгийн хуулийн тусгай ангид:

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, ФАТФ-ын зөвлөмж, 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд бусдын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, хадгалах, борлуулах гэмт хэргийг хуульчилж байсан уламжлалыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлгийн 17.13 дугаар зүйлд бусдын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, хадгалах, борлуулах үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцсон өөрчлөлтийг тусгав.

Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн "Албан тушаалын гэмт хэрэг" гэсэн 28 дугаар бүлгийн 272 дугаар зүйлд "Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах" гэмт хэргийг хуульчилсан байсан уламжлал, энэ төрлийн гэмт хэргийн субъектын шинжийг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлгийн 22.15 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцсон өөрчлөлтийг тусгав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1-д "Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.", 45.2-д "Энэ хуулийн 45.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загвар, хөтлөх, шийдвэрлэх журмыг Ерөнхий зөвлөл батална." гэж тус тус заасан.

Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээд нөлөөлөх байдлыг таслан зогсоох зорилгоор Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.16 дугаар зүйлд шүүгч хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй, эсхүл бүрэн бус, худал хөтлөх үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцсон өөрчлөлтийг тусгалаа.

Түүнчлэн шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх (Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл) гэмт хэргийн объектив талын шинжид эдгээр албан тушаалтанд бусад байдлаар нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн үйлдлийг нэмэх өөрчлөлтийг тусгасан. Мөн энэ зүйлийн үндсэн зорилгоор тусгайлан заасан үйлдлийг нэмэх өөрчлөлтийг тусгалаа.

албан тушаалд ажиллаж байгаа болох өмнө нь ажиллаж байсан хүнийг ойлгохоор хүрээг өргөжүүлсэн.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр¹ манай улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох эрсдэлтэй гэмт хэргийг үнэлсэн бөгөөд уг үнэлгээгээр 1.авлигын, залилах, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүд өндөр эрсдэлтэй, 2.татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд дунд эрсдэлтэй, 3.хөрөнгө завших, хулгайлах, мал хулгайлах гэмт хэргүүд бага-дунд эрсдэлтэй, 4.улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд бага эрсдэлтэй гэж дүгнэсэн.

Гэвч мөнгө угаах гэмт хэргийг сүүлийн 4 жил эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 193 хүнд холбогдох 172 хэргийг шийдвэрлэжээ.² Нийт суурь гэмт хэргээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 154 буюу 90.5 хувийг, эдийн засгийн гэмт хэрэг 2 буюу 1 хувийг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг, авлигын гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 2.3 хувийг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн дийлэнх хувийг өмчлөх эрхийн эсрэг (хулгайлах, мал хулгайлах, залилах, дээрэмдэх) гэмт хэрэг эзэлж байна.

Мөнгө угаах гэмт хэргээр нийт 193 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэснээс бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаасан хүн 160 буюу 83 хувийг, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаасан хүн 33 буюу 17 хувийг тус тус эзэлж байгаа судалгаа байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт бүх гэмт хэргийг хамаарахаар хуульчилсан атал зөвхөн дээр дурдсан өмчлөх эрхийн эсрэг зарим гэмт хэргийн хүрээнд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлэх практик тогтсон гэж үзэж болохоор байна.

Иймд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг олон улсын гэрээ, конвенц, ФАТФ-ын зөвлөмж, суурь гэмт хэргийг тодорхойлох олон улсын аргачлалыг харгалзан тодорхойлж, бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаах, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаах үйлдлийг ялгамжтай байдлаар төсөлд тусгалаа.

Мөн энэ гэмт хэргийг виртуал хөрөнгө ашиглаж, хуулийн этгээдийг халхавчаар ашиглаж, үндэстэн дамнаж үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр нэмсэн өөрчлөлтийг тусгав.

Албан тушаалын эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл) гэмт хэргийн хохирлын хэмжээнээс хамаарч ялын бодлогыг ялгамжтай тодорхойлж, энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний

¹ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ. УБ., 2020

² Б.Батцэрэн. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, ял оногдуулах асуудал. Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Түлгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам олон улсын

хохирол учруулсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр төсөлд өөрчлөлтийг тусгав.

Нийтийн албан тушаалтан хахууль авах (Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл) гэмт хэргийн объектив талын шинжийг олон улсын туршлага, гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжийг харгалзан бусад этгээд, эсхүл төлөөний хүнд хахууль өгүүлэх, өгүүлэхээр тохиролцох, өгөхийг шаардах үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцсон. Хууль хэрэглээний нэгдсэн байдлыг хангах зорилгоор бусад этгээд болон төлөөний хүнд хамаарах этгээдийг хууль тогтоогчийн тайлбар хэсэгт заасан.

Мөн энэ гэмт хэргийн 2 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр төсөлд өөрчлөлтийг тусгав.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, олон улсын туршлага, гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжийг харгалзан хууль бусаар хөрөнгөжих (Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл) гэмт хэргийн нэрийг өөрчилсөн. Мөн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, практик тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор “хөрөнгө, орлого”, “онц их хэмжээ”, “их хэмжээ” зэрэг нэр томъёог хууль тогтоогчийн тайлбарт тусгасан.

Сүүлийн жилүүдэд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах (Эрүүгийн хуулийн 22.13 дугаар зүйл) гэмт хэргийн гаралт, хахуулийн хэмжээ, гэмт этгээд энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдэх байдал нэмэгдэх хандлагатай байна.

Иймд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан, энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хахууль авсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх өөрчлөлтийг тусгав.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл батлагдан хэрэгжвэл нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах ажлын ачаалал нэмэгдэх байдал, авлигын гэмт хэрэг шалгахад орон нутаг бүрт нэгж, хүний нөөц бүхий цагдаагийн байгууллагын хүний нөөц, хүчийг нэмж ашиглах нь зүйтэй байгааг харгалзан авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын харьяаллыг авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллага өөрсдийн илрүүлсэн хэрэгт явуулах буюу давхар харьяалалтай байх өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулахаар тусгалаа.

5. Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай анхдагч хуулийн төслийн талаар

Тус хуулийн төсөл нь шүүх, прокурор, мөрдөгч хуульд заасны дагуу түр болон бүр хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдахтай холбоотой харилцааг зохицуулах зорилготой.

Хөрөнгө эрхлэн удирдах байгууллагын тогтолцоо, хөрөнгө эрхлэн удирдах үйл ажиллагаанд эдгээр байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх, чиг үүргийг тусгалаа.

Тус хуулийн төсөлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлж улсын орлого болгосон хөрөнгө, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд тусгагдсан, шүүхийн шийдвэрээр түр болон бүр хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдах зохицуулалтыг тусгалаа.

6.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Тус хуулийн төсөлд хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн эрх зүйн үндсийг хуульчлан, тухайн хөрөнгөнөөс олсон орлогыг авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд 10 хувийг; хүн амын эрүүл мэнд, боловсролыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 90 хувийг зарцуулахаар хуульчилсан. Мөн хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн удирдах зөвлөлтэй байхаар тусган, уг удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоотой байлгахаар эрх мэдлийг жигд хуваарилсан байдлаар тусгав.

Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу хөрөнгө төвлөрүүлэх бөгөөд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран, хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн дүрэм, удирдах зөвлөл, түүний Ажлын албаны бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журам болон уг сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг Засгийн газар батлах талаар тусгасан.

7.Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Авлигатай тэмцэх газар нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах чиг үүргийг нэмж, тус явуулахдаа Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг баримтлах талаар тусгав. Үүнээс гадна иргэн, хуулийн этгээд авлигын талаар өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх асуудлыг тусгав. Мөн авлигын мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах, мэдээллийг нууцлах талаар тусгаж, урамшуулах үндэслэлийг “тухайн мэдээлэл нь хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар нотлогдож, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд” гэж тусгалаа.

8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Тус хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл

хуулийн зарим заалтад “мэдээлэгч” гэсэн нэр, томъёог дүйцүүлэн нэмж, авлигын мэдээлэгчийг мэдээлэгчид хамруулан шаардлагатай тохиолдолд тус хуульд заасан хамгаалалтад авахаар тусгалаа.

9.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Цагдаагийн албаны гүйцэтгэх чиг үүрэгт “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа” гэсэн ажиллагааг нэмж, эрх зүйн үндсийг бүрдүүлэн, зарим зүйл заалтад “хууль бус хөрөнгө шалгах” гэсэн нэр, томъёог нэмэхээр тусгасан.

10.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төрийн аудитын тухай хуулийн хэм хэмжээг зохицуулсан харилцааг бататган, “Чанарын хяналт”, “Чанарын баталгаажуулалт”, “Шалгагдагч этгээд” нэр томъёог нэмж тайлбарлан, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, удирдлагад аудит хийх, төр, орон нутаг хяналтын багц буюу түүнээс хувийн хувьцааг нь эзэмшдэг компани, түүний охин компанид аудит хийхдээ төр, орон нутгаас хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг шалган дүгнэх, улсаас зээл авсан, улсаас гаргасан татаасын тусламжтайгаар хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр ашигласан этгээдийн тухайн зээл, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийн ашиглалт, өрийн баталгаа гаргуулагчийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд аудит хийх харилцааг нэмэхээр тусгалаа.

Төрийн аудитын чанарын удирдлага, Монгол Улсын Ерөнхий аудиторыг нэр дэвшүүлэх, томилох журам, Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох, акт, албан шаардлагын биелэлтийг хангах харилцааг мөн нэмж тусгасан.

11.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нөлөөллийн мэдүүлэг болон Төрийн албаны тухай хуулийн 11.1.6, 11.1.7, 11.1.8, 12.1.4-т заасан этгээд этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэж, битүүмжлээгүй, эсхүл Ерөнхий зөвлөлд ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүргээ 3 болон түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болох тусгав.

12.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө түр хураах тухай шүүгчийн захирамж, Эрүүгийн хууль болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон шүүхийн шийдвэр гэсэн заалтуудыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлд нэмж тусган, хураагдсан хууль бус хөрөнгө, орлогыг хадгалах, хамгаалах, худалдах эрх зүйн үндсийг тус хуульд нэмж тусгав.

Мөн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгийг түр хураан авсан, хураан авч улсын орлого болгосон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа "Арван гуравдугаар"¹ бүлгийг нэмж, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгийг түр хураасан, хураан авч улсын орлого болгосон шийдвэрийг биелүүлэх ажиллагааг нэмж тусгалаа.

13.Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Прокурорын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон тус хуульд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт, бүрэн эрх, хяналтын хэлбэр, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх асуудлаар шүүх хуралдаанд оролцох болон төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээг нэмэгдүүлж тусгав.

14.Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэлд Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллахыг нэмж тусгав.

15.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, хураан авах ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээс нийтийн албан тушаалтанд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр тусгав.

16.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугар зүйлд заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн чиг үүргийг практикт цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас түлхүү хэрэгжүүлж байна. Иймд тус зөвлөлийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах нь илүү тохиромжтой гэж үзэж тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.17 дахь заалтыг өөрчлөн найруулж Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, төрийн захиргааны төв байгууллага, холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн, нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллахаар тусгалаа.

17.Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Тус хууль нь нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогод хамаарахгүй байхаар тусгалаа.

18.Мөн хуулийн төслийг дагаж Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу тус яамны албан ёсны цахим хуудсанд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байршуулсан бөгөөд хуулийн төслийг олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, төрийн байгууллага, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагч, хуульч эрдэмтэн, судлаач гэсэн 2 хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 10, 14-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 150 гаруй хүн оролцож саналаа илэрхийлсэн ба үүнд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллөөс хуулийн төслийг яаралтай батлуулах, хууль батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтэд анхаарах, хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог тодруулах, шинэчлэх, хуулиа сурталчлах, хууль хэрэгжилтэд гарч болзошгүй асуудлын талаар асуулга ирүүлсэн ба шаардлагатай саналуудыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр холбогдох төрийн байгууллагуудаас санал авахаар Улсын Дээд Шүүх, Хүний эрхийн Үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, төрийн захиргааны төв байгууллагууд, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг нийт 44 байгууллагад хүргүүлсэн. Энэ хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Улсын Дээд Шүүх, Хүний эрхийн Үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, төрийн захиргааны төв байгууллагууд, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг нийт 26 байгууллагаас санал ирүүлээд байна.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналыг судлан ажиллаж, хуулийн төсөлд үндэслэлтэй саналуудыг тусгаж ажилласан болно.